


# ҮГИЙН СҮЛЖЭЭ



## Across

3. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримтлах зарчим.  
 4. Гүйлгээг ерөнхий дэвтрийн дансанд шилжүүлэхийн өмнө цаг хугацааны дараалаар нь бүртгэх бичилт.  
 5. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Институтын удирдах зөвлөлийн шийдвэрээр хүчингүй болгох тохиолдол.  
 10. Аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд.  
 11. Аудитын хуулийн этгээд хөрөнгийн үнэлгээ, татварын болон нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгч байгууллагынхаа тухайн санхүүгийн \_\_\_\_\_ тайланд аудит хийхийг хориглоно.  
 15. Нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг олгох газар.  
 17. Аудитын ажлын баримт нь аудитын хуулийн этгээдийн өмч бөгөөд ажлын баримтыг \_\_\_\_\_ жил хадгална.  
 20. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээр ямар мөнгөн тэмдэгтээр бүртгэх вэ?  
 21. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа бүрдүүлэх материал.  
 23. Гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт.

24. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хэдэн дараалалтайгаар гүйцэтгэх вэ?  
 26. Нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэх зүйлсийн нэг.  
 27. Санхүүгийн мэдээллийг холбогдох олон улсын стандартын дагуу шалган баталгаажуулах үйл ажиллагаа.  
 28. Аудит хийлгэсэн үйлчилгээний хөлсийг \_\_\_\_\_ үндсэн дээр төлнө.  
**Down**  
 1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газарын нягтлан бодох бүртгэлээ хөтлөх хэл.  
 2. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг хариуцагч.  
 6. Аудитын хуулийн этгээд нь аудитын дүгнэлтийн талаар хэний хөрөнгөөр хариуцлага хүлээх вэ?  
 7. Аудиторын дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулах хүн.  
 8. Компаниас бусад хуулийн этгээдийн хувьд тухайн хуулийн этгээдийн дүрэмд гүйцэтгэх удирдлага гэж заасан этгээд.  
 9. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаар нэмэлт тайлбар, тодруулга шаардах эрхтэй этгээд.  
 12. Нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг олгох хүн.

13. Байгууллагын санхүүгийн тайланг бүрдүүлж байгаа бүх данс.  
 14. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21.1-д заасан хороо.  
 16. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ хөтлөх суурь.  
 18. Аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол хаана гомдол гаргах вэ?  
 19. Тусгай зөвшөөрөл авсан аудитын хуулийн этгээдийн оноосон нэрийн ард хэрэглэх үг.  
 22. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.13-т заасан байгууллага.  
 25. Аудит хийлгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага.